

лөлт, шинэ сэтгэлгээний үзэл санаа, улсын эдийн засаг, хөгжлийн шаардлага, төлөвийг харгалзан БНМАУ-ын аюулгүй байдлын чиг баримтлалыг ч эргэн харж, үндэслэлтэй боловсруулах цаг болсон гэж үзэж байна. Улс орны аюулгүй байдлыг улс төрийн аргаар бэхжүүлэх, цэрэг зэвсгээ хорогдуулах боломж, нөхцөл нэмэгдэж байгааг анхаарах хэрэгтэй юм.

Ийнхүү гадаад бодлогын үйл ажиллагаа, арга барилдаа өөрчлөлт шинэчлэлийн үзэл санааны дагуу зарчимт дүн шинжилгээ хийж хуучин сэтгэлгээг зоригтой таягдан хаяхад гадаад харилцааны салбарт ажиллаж байгаа бүх шатны боловсон хүчин, дипломатууд, мэргэжилтнүүдийн санаачилгатай, бие даасан бүтээлч ажил туйлын чухал юм

Орчин үеийн олон улсын харилцааны тулгуур асуудлуудыг нарийн мэддэг, дипломатын урлаг, үр дүнг сайн эзэмшсэн, эх орон, ард түмнийхээ түүх, соёлын уламжлал, хөгжлийн асуудлуудыг гүнзгий судалсан, гадаад хэлний өргөн мэдлэгтэй мэргэжилтэн, дипломат ажилтнуудын эгнээг өргөтгөхөд боловсон хүчний чиглэсэн зорилготой программ боловсруулан мөрдөж, тэднийг шилж сонгох, давтан сургах, дадлагажуулахад гоц анхаармаар байна. Гадаад бодлогын салбар дахь шинэчлэл, өөрчлөлтийн нэг чухал чиглэл чухамхүү үүнд оршиж байна. Сэтгэлгээ, арга барилын шинэчлэлээс ажлын эцсийн үр дүн, тодруулбал манай улсын гадаад харилцааны үр өгөөж хамаарах нь дамжиггүй.

МАХН-ын Төв Хорооны тавдугаар (1988 он) бүгд хурлаас хойшхи богинохон хугацаанд гадаад улс төрийн болон эдийн засгийн харилцааг шинэчлэх, үр өгөөжийг нь дээшлүүлэх, цаг үеийн шаардлагад нийцүүлэх талаар холбогдох байгууллагууд тодорхой ажил хийж эхэлсэн бөгөөд гагцхүү тэр үйлсээ туйлд нь хүргэх эрхэм зорилт үлдээд байгааг эцэст тэмдэглэе.

1. Монгол Ардын Хувьсгалт Намын Төв Хорооны V бүгд хурал, Улаанбаатар, 1988, 23 дахь тал
2. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын гадаад харилцааны баримт бичгүүдийн эмхтгэл, 1 боть, УБ, 1961 он, 7—8 дахь тал
3. «БНМАУ-ын их, бага хурлын тогтоол, Үндсэн хууль, тунхагууд», Улсын хэвлэлийн газар, УБ., 1956, 99 дүгээр тал

**ОЛОН УЛСЫН КОММУНИСТ
ХӨДӨЛГӨӨНИЙ ТҮҮХ, ОРЧИН ҮЕИЙН
АСУУДЛААР БНХАУ-д ХИЙГДЭЖ БУЙ
СУДАЛГААНЫ АСУУДАЛД**

Ш. Эрдэнэчимэг

Олон улсын коммунист хөдөлгөөний дотор улс төрийн шинэ сэтгэлгээ бүрэлдэж байгаа өнөөдрийн нөхцөлд ах дүү намууд бие биеэ харилцан хүндэтгэх зарчимд тулгуурлан өөр өөрсдийн үзэл бодлоо өргөнөөр байнга солилцон харьцуулан үзэх явдал чухал болж байна.

Өөрийн үзэл бодолтой нийлэхгүй байгаа нөгөө талын үзэл бодлыг үгүйсгэдэг хуучин зуршлаас салах хэрэгтэй болсныг ах дүү намууд тэмдэглэж байна.

Энэ үүднээс бид коммунист хөдөлгөөний асуудлуудаар бусад нам, орны эрдэмтдээс явуулж байгаа судалгааны чиглэл, судалгааны арга барилыг судалсны үндсэн дээр нийтлэг байр суурьтай асуудлуудаар хамтран ажиллах нь чухал юм. Үүнтэй холбоотойгоор манай хөрш зэргэлдээ БНХАУ-д хийгдэж байгаа судалгааны талаар доор өгүүлнэ.

Сүүлийн жилүүдэд ХКН-аас олон улсын коммунист хөдөлгөөн, ах дүү намуудтай тогтоосон холбоо харилцаагаа идэвхжүүлж, 1960-аад оноос холбоо харилцаа тасарсан олон намуудтай харилцааг сэргээж байна. ХКН «4 зарчим»-ын үндсэн дээр, тухайлбал, «бие даасан, хараат биш байх, бүрэн тэгш эрх, бие биеэ харилцан хүндэтгэх, дотоод хэрэгт үл оролцох» зарчмын үндсэн дээр янз бүрийн орны коммунист болон ажилчин ангийн бусад бүх намтай харилцаа тогтоон хөгжүүлнэ гэж мэдэгдэж байна. ХКН-аас нам хоорондын харилцааны зарчмуудын талаар баримталж байгаа байр суурийг ХКН-ын XII их хурлаас тодорхойлохдоо «Аливаа орны хувьсгалын амжилт нь тухайн орны нөхцөл бүрэлдэж, коммунист намын чиг шугам өргөн олон түмний дэмжлэгийг хүлээсэн эсэхээс шалтгаална. Орон бүхний намууд харилцан туслалцах нь мэдээж хэрэгтэй, гэвч гаднаас даралт шахалт үзүүлэх, бусдын өмнөөс ажиллах, хариуцлагыг өөртөө авах явдлыг зөвшөөрч болохгүй юм. Өөрийн үзэл бодлыг бусдад тулган хүлээлгэх, бусад орны намын дотоод хэрэгт оролцох явдал нь тухайн орны хувьсгалын хэрэг бүтэмжгүй болоход хүргэдэг байна.

Орон бүхний нам харилцан бие биеэ хүндэтгэх явдлыг бид дэмждэг. Орон болгоны нөхцөл байдал өөр учир, нөхцөл байдал, зорилтын талаарх нам бүрийн үзэл бодол бүрмөсөн адил байх аргагүй юм. Үзэл бодлын ялгааг зөвхөн нөхөрсгөөр харилцан ярилцаж, харилцан хүлээцтэй байх замаар давж болно. Бид аливаа нам өөр намын ололт туршлага, алдаа дутагдлаас суралцах явдлыг сайшаадаг бөгөөд энэ нь олон улсын коммунист хөдөлгөөний хөгжилд ач тустай гэж үздэг юм»¹ гэжээ.

Намууд тэгш эрхтэй, шударга байх үндсэн дээр бие биеэ дэмжин, санал солилцох, харилцан суралцахыг бид үгүйсгэдэггүй. Харин «нийтлэг зүй тогтол», «хамтын стратеги», «зохицуулсан үйл ажиллагаа» зэрэг томъёоллыг дэмждэггүй» гэж ХКН-ын ТХ-ны ГХХ-ийн эрхлэгч 1985 онд «Ляован» сэтгүүлийн сурвалжлагчтай ярилцахдаа хэлжээ.

Одоо ХКН дэлхийн коммунист, ажилчны болон бусад янз бүрийн улс төрийн 200 гаруй нам, байгууллагатай харилцаатай байна («Жэньминь жибао», 1986—VI—30). Зөвхөн 1986 онд дэлхийн 5 тивийн 50 гаруй орны улс төрийн 65 намын 102 удаагийн төлөөлөгчид Хятадад айлчилж, ХКН-ын 32 удаагийн төлөөлөгчид дэлхийн 32 оронд айлчилж, улс төрийн 47 намтай яриа хэлэлцээ хийсэн байна. Мөн улс төрийн 25 намын дээд хэмжээний төлөөлөгч, Социалист интернационалын нарийн бичгийн дарга БНХАУ-д айлчилжээ.² 1986 онд ХКН Сирийн Арабын сэргэн мандалтын социалист нам, Боливийн баруун жигүүрийн хувьсгалт хөдөлгөөн, Финляндын социалист ардчилсан нам, Мальтын Социализмын тэмцлийн хөдөлгөөнтэй албан ёсны харилцаа тогтоож Их Британийн Коммунист Нам, Финляндын Коммунист Нам, Австралийн Коммунист Нам, Шри Ланкийн Коммунист Намтай хоёр намын ха-

рилцааг сэргээв. 1986 онд О. Мадригар тэргүүтэй Коста-Рикийн ардын манлай намын төлөөлөгчид БНХАУ-д айлчилсан нь тус намаас сүүлийн 20 жилд Хятадад айлчлан ирсэн анхны төлөөлөгчид юм. С. Акста тэргүүтэй Эквадорын социалист намын төлөөлөгчид айлчилсан нь тус социалист намаас анх удаа Хятадад ирсэн төлөөлөгчид байв. ХКН-ын төлөөлөгчид нэлээд хэдэн коммунист намын их хуралд оролцож Социнтерны 17-р их хуралд ажиглагчаар оролцжээ. Мөн ХКН-ын төлөөлөгчид ах дүү намуудын ойн арга хэмжээнд оролцсон байна. Тухайлбал, 1986 онд ХКН-ын төлөөлөгчид Шинэ Зеландын ажилчны намын 70 жилийн ой, Их Британийн ажилчны намын 85 жилийн ой, Никарагуагийн Сандиногийн үндэсний чөлөөлөх фронтын 25 жилийн ойн арга хэмжээнд оролцжээ³. Коммунист хөдөлгөөний талаарх Хятадын удирдлагын бодлого идэвхжиж байгаатай холбогдон сүүлийн үед БНХАУ-д коммунист хөдөлгөөний асуудлаар судалгааны ажил идэвхжиж байна. 1980 онд олон улсын коммунист хөдөлгөөний түүх судлах Бээжингийн нийгэмлэг, 1982 онд олон улсын коммунист хөдөлгөөний түүх судлах Хятадын нийгэмлэгийг байгуулав. Түүнээс хойшхи жилүүдэд Хятадын бүх мужуудад коммунист хөдөлгөөний түүх судлах нийгэмлэгүүд байгуулагджээ. Одоо бүх Хятадын хэмжээгээр 1339 судлаачид эдгээр нийгэмлэгүүдэд хамрагдан ажиллаж байна. Мөн К. Маркс Ф. Энгельс, В. И. Лениний зохиол бүтээлийг орчуулж нийтлэх ажлыг өргөжүүлж, Г. В. Плеханов, В. И. Сталин, Н. И. Бухарин, М. С. Горбачев, Ким Ир Сен, Н. Чаушеску, И. Б. Тито нарын зохиолын түүвэр. Г.Е. Зиновьевын захидлууд гарчээ.

Коммунист хөдөлгөөний түүх, орчин үеийн асуудлаар судалгааны нэлээд хэдэн бүтээл гарчээ. Тухайлбал, сүүлийн жилүүдэд «Орчин үеийн коммунист хөдөлгөөний түүх», «Олон улсын коммунист хөдөлгөөний түүх», «Олон улсын коммунист хөдөлгөөний түүхийн баримт бичгүүд», «Коммунист хөдөлгөөн ба Хятад» зэрэг бүтээлүүд БНХАУ-д нийтлэгджээ. Эдгээр бүтээлүүд болон тус оронд гарч байгаа «Олон улсын коммунист хөдөлгөөн», «Олон улсын коммунист хөдөлгөөний түүхийн судлал», «Социализмын судалгаа», «Марксизмын судалгаа», «Орчин үеийн дэлхийн социализмын асуудал» зэрэг онолын сэтгүүлүүд болон Хятадын мужийн их сургуулиудын хэвлэлд нийтлэгдсэн судалгааны өгүүллүүдээс БНХАУ-д коммунист хөдөлгөөний түүх, орчин үеийн асуудлуудыг ямар хүрээнд судалж байгаа нь ерөнхийдөө тодорхой болж байна. 1986-1987 онд эдгээр онолын сэтгүүлүүдэд: «Марксизм үүсэн бий болсон эх үүсвэрийн талаарх судалгаа»⁴, «Социалист лагерийн түүхийн судалгаа»⁵, «Ажилчин ангийн олон улсын нэгдэл холбооны хэлбэрийн зарим асуудал»⁶, «Коммунист намын тунхагийн» үндсэн санааг хэрхэн ойлгох тухай»⁷, «Эрфуртын программ бол марксизмын программ мөн»⁸, «II Интернационалын зохион байгуулалтын хэлбэр»⁹, «Майн нэгний баяр үүссэн тухай»¹⁰, «Энгельс ба нийгмийн тэмцэл»¹¹, «Энгельс амьдралынхаа сүүлийн жилүүдэд дайн, зэвсэг хураах асуудлын талаар»¹³, «Коминтерн ба Хятадын их хувьсгал»¹⁴, «Коминтерн ба ХКН холбоо тогтоосон асуудалд»¹⁵, «Коминтерн ба дэлхийн II дайны үеийн «зүүний» хэлбэрлийн алдааг дахин танин мэдэх тухай»¹⁶, «Ленин ба нэг оронд социализм байгуулах тухай онол»¹⁷, «Ленин ба эдийн засгийн талаар хоцрогдсон оронд социализм байгуулах тухай судалгаа» зэрэг өгүүллүүд бичигджээ.

Эдгээр бүтээлүүдээс үзэхэд олон улсын коммунист хөдөлгөөний түүх, орчин үеийн асуудлаар БНХАУ-д хийгдэж байгаа судалгааны хүрээ, чиглэлүүд харагдаж байна.

Нэгдүгээрт, Хятадын эрдэмтэд К. Маркс, Ф. Энгельс, В. И. Лениний зохиол бүтээлийг авч үзэхдээ Хятадад хийгдэж байгаа шинэчлэлт, эдийн засгийн хувьд хоцрогдсон оронд социализм байгуулах тухай асуудал, мөн орчин үеийн нэг гол чухал асуудал болсон дайны аюулыг зайлуулах, зэвсэглэлийг хорогдуулах асуудалтай холбон үзэж байна.

Хоёрдугаарт, Сүүлийн үед Хятадын судлаачид дэлхийн социализмын асуудал, ЗХУ-д хийж байгаа өөрчлөн байгуулалтын асуудлыг их бичих болов. Үүний зэрэгцээ тэд ХКН, ЗХУКН, бусад социалист орны ах дүү намтай тогтоосон харилцааны түүхийг авч үзэж дүн шинжилгээ хийж, өөрсдийн сууринаас үнэлэлт дүгнэлт өгч байна.

Гуравдугаарт, Хэрвээ урьд Хятадын түүхчид олон улсын коммунист хөдөлгөөн, хятадын хувьсгалын хэлхээ холбооны асуудлыг үгүйсгэж байсан бол, одоо энэ хоёрын холбоо харилцааны асуудалд анхаарал тавьж судлах болжээ. Тухайлбал, Хятадын эрдэмтэн Чжао Баосю бичихдээ: «Олон улсын коммунист хөдөлгөөн бол эхнээсээ аваад олон улсын шинжтэй байв. Хятад дахь коммунист хөдөлгөөн чухал бүрэлдэхүүн хэсэг болж байгаагүй гэх аргагүй юм. Урьд өмнө бид ХКН-ын түүхийн судалгаа, олон улсын коммунист хөдөлгөөний судалгаа хоёр тусдаа, өөр хоорондоо холбоогүй зүйл хэмээн үзэж байв. Гэтэл үнэн хэрэгтээ ХКН-ын түүхийн олон чухал асуудлыг олон улсын коммунист хөдөлгөөний түүхээс салангид авч үзэх аргагүй юм. Харин одоо ХКН-ын түүх судлаачид энэ хоёрын харилцаа холбоонд анхаарал тавих болов»¹⁸ гэжээ.

Хятадын судлаачид Коминтерн, Хятадын хувьсгалын холбоо харилцааны асуудлыг судлахдаа, ХКН-аас Коминтернтэй тогтоосон холбоо нь маш зөрчилтэй байсан гэж үзэж байна. Хятадын түүхч Ляо Гайсян бичихдээ: «Коминтерн байгуулагдсаныхаа эхний үед ХКН байгуулагдан өсч бэхжихэд тусалсан, мөн Хятадын анхдугаар их, хувьсгал эхний болон дунд үе шатандаа амжилт олоход туслалцаа үзүүлсэн юм. Гэвч Коминтерны удирдлага Хятадын бодит байдлыг мэдэж ойлгохгүй байсны гадна Хятадын ажилчин анги, ХКН ба Хятадын тариачдын гүйцэтгэх үүрэг ролийг дутуу үнэлж, Хятадын хөрөнгөтөн анги, Гоминдан ба Чан Кайши, Ван Цзинвэй, Фын Юйсян нарын хувьсгалч шинжийг хэтрүүлэн үнэлж байв. Энэхүү алдаатай үзлийн шууд нөлөөн дор Хятадын анхдугаар их хувьсгал амжилтанд хүрээгүй юм»¹⁹ гэж бичжээ. Ли Шу гэгч судлаач бичихдээ: Хятадын хоёрдугаар иргэний хувьсгалт дайны үед гурав дахь «зүүний нугалаа алдаа гарах болсон дотоод дахь гол шалтгаан нь манай намын доторхи жижиг хөрөнгөтний үзэл санаа улс төрийн хувьд авантюризм, зохион байгуулалтын хувьд фракц бий болсон явдлаар илэрсэн явдалтай холбоотой юм. Гадаад шалтгаан гол нь Коминтерны хэт зүүний онолын удирдлага, ялангуяа Коминтерн зохион байгуулалтын талаас Хятадын хувьсгал ба ХКН-ын дотоод ажлыг шүүрч аван хариуцлагыг өөртөө татаж байсантай холбоотой юм.²⁰ гэжээ.

Сүүлийн үед Коминтерний талаар Хятадын судлаачдын бичсэн зүйлийг авч үзвэл, тэд нэгдүгээрт, Коминтерны зохион байгуулалтын зарчмууд, хоёрдугаарт, Коминтерны үйл ажиллагаа гэсэн 2 чиглэлээр

судалгаа явуулж байгаа нь харагдаж байна. Коминтерны зохион байгуулалтын зарчмуудыг авч үзэхдээ, Хятадын судлаачид «Коминтерн хэдийгээр ардчилсан төвлөн удирдах зарчмыг зохион байгуулалтын зарчим гэж үздэг боловч, үнэн хэрэг дээрээ Коминтерны Гүйцэтгэх хорооны төвийн төвлөрсөн удирдлагын системийг бий болгосон юм, ингэснээрээ Коминтерн ноцтой алдаа хийхэд хүрсэн юм. Коминтерн ардчилсан төвлөн удирдах зарчмыг хэрэгжүүлж чадаагүй явдал нь дотоод, гадаад шалтгаантай юм»²¹ гэжээ. Коминтерны үйл ажиллагааны асуудалд хандахдаа, хятадын эрдэмтэд түүний бодлогын зөв болон алдаатай талыг тэмдэглэж байна. Хятадын түүхч У Цзяньсин бичихдээ: «Коминтерны 7-р их хурлын түүхэн гавьяа нь: ард түмэн фашист хүчний харгис шинж чанарыг танин мэдэхэд тус болж, фашизмыг эсэргүүцсэн нэгдсэн фронтын бодлогыг боловсруулан тавьж, фашизмын эсрэг орон бүхний ард түмний тэмцлийг идэвхжүүлсэнд оршино. Алдаа дутагдалтай тал нь: Коммунист нам нэгдсэн фронтын дотор өөрийн биеэ даасан байх зарчмыг цохон тэмдэглээгүй бөгөөд энэ нь фашизмыг эсэргүүцэх орон болгоны хөдөлгөөн Зөвлөлтийг сохроор дагахад хүргэсэн юм»²² гэжээ.

Үүний зэрэгцээ ХКН-ын түүхэнд гарсан «соёлын хувьсгал» гэгчийг дэлхийн коммунист хөдөлгөөний нэг бүрэлдэхүүн хэсэг болох ХКН-ын дотор гарсан нэг үзэгдэл гэдэг үүднээс судлах хэрэгтэй байгааг сүүлийн үед хятадын түүхчид бичих болов. Энэ талаар БНХАУ-д явуулж буй судалгаа бусад орны судалгаанаас хоцорч байгааг тэд тэмдэглэж байна. Ер нь Хятадын хувьсгал ба бусад орны хувьсгалын талаар харьцуулсан судалгаа хийх хэрэгтэй гэж үзэж байна.

Мөн коммунист хөдөлгөөний үечлэлийн тухай асуудлыг нарийвчлан судлах шаардлагатай байгаа тухай тэд бичиж байна.

Дөрөвдүгээрт, ХКН сүүлийн үед социал-демократ намуудтай харилцааг хөгжүүлж байгаатай уялдан Хятадын онолын сэтгүүлүүдэд Социал-демократ намуудын бодлогын тухай нэлээд бичиж байна. Энэ асуудлаар бичиж байгаа судлаачид сүүлийн 30 жилийн дотор Социалист Интернационалын бодлогын хөгжилд бие даах, бодитой хандах, дэвшилт шинж чанар улам хүчтэй болж байна гэж үзжээ

БНХАУ-д сүүлийн жилүүдэд олон улсын коммунист хөдөлгөөний түүхийн судалгааны арга, аргазүйн асуудлаар судалгаа идэвхжиж байгаа нь ажиглагдаж байна. 1980 онд ХКН-ын Төв Хорооны дэргэдэх Хятадын коммунист хөдөлгөөний түүх судлах нийгэмлэгээс эрхлэн жилд 3 удаа гардаг «Олон улсын коммунист хөдөлгөөний түүхийн судлал» гэсэн сэтгүүл, мөн «Олон улсын коммунист хөдөлгөөн» гэсэн онолын сэтгүүлд энэхүү асуудлаар нэлээд олон өгүүлэл нийтлэгдэж байна. Хятадын эрдэмтэд хятадын онцлог бүхий олон улсын коммунист хөдөлгөөний түүх судлалыг хөгжүүлэхийг уриалж байгаа бөгөөд үүнийг хэрэгжүүлэх нөөц боломж Хятадад бий гэж үзэж байгааг тэмдэглэх хэрэгтэй. Үүнд: Хятадын судлаачид олон улсын коммунист хөдөлгөөний түүхийн асуудалд хандахдаа ХКН-ын 1978 оны III бүгд хурлаас дэвшүүлсэн «практик бол туршилт сорилтын үнэний ганцхан шалгуур», «хоёр талын алиныг ч» шүүмжлэх гэсэн марксизмын практикийг үндэс болгосон үзэл санааг удирдлага болгох нь зүйтэй гэж үзэж байна. Тэд марксизмыг удирдлага болгон шинжлэх ухааны үндэстэй судалгаа явуулна гэж бичиж байна, гэхдээ Марк-

сизмыг догм болгосон явдлыг даван туулж, ХКН-ын ТХ-ны III бүгд хурлаас тэмдэглэснээр марксизмын үнэн нүүр царайг сэргээж, удирдлага болгоно»²⁴ гэж бичжээ. Энэ зарчмыг Хятадын эрдэмтэд баримталж байгаа нь тэдэнд судалгаа хийх давуу талыг олгож байна гэж тэд үзэж байна. Нөгөө талаас, тэд коммунист хөдөлгөөний асуудлыг судлахад оршиж буй бэрхшээлтэй талуудыг тэмдэглэж байна.

а) Олон улсын коммунист хөдөлгөөний орчин үе, түүхийн асуудал нь улс төрийн шинж чанарыг маш хүчтэй агуулсан асуудал бөгөөд иймээс улс төрийн шинж чанар, шинжлэх ухааны шинж чанар хоёр хоорондоо зөрчилтэй асуудал юм гэж тэд үзэж байна. «Онолын талаас авч үзвэл энэ хоёр зөрчилгүй юм. Гэвч практик дээр шинжлэх ухааны шинж чанар нь улс төрийн шинж чанарын шаардлагад захирагдан зохицох явдал гардаг байна»²⁵ гэж эрдэмтэн Жао Баосю бичжээ.

б) Хятадын судлаачдын үзэж байгаагаар, 1950-иад оны дунд үеэс хойш коммунист хөдөлгөөний судлаачид бараг бүгд «Зөвлөлтийн Коммунист (большевик) Намын түүхийн товч программыг» гол үлгэр болгон авсан нь судалгаанд догматизм бий болгоход нөлөөлөв.

в) Урьд өмнө янз бүрийн объектив, субъектив шалтгааны улмаас Хятадын судлаачдад коммунист хөдөлгөөний асуудлыг судлах гол материал нь эх сурвалж бичиг биш, хоёр дахь гарын материал байжээ. Энэ нь тэдний үзэж буйгаар, судалгаа бодит, шинжлэх ухааны үндэстэй байхад муугаар нөлөөлжээ.

г) «Салхины аяс дагадаг» явдлыг даван туулах хэрэгтэй гэж тэд үзэж байна. «Салхины аяс дагадаг» явдал тухайлбал, түүхэн хүмүүст үнэлэлт дүгнэлт өгөх асуудал дээр илэрсэн юм²⁶ гэж Жао Баосю бичжээ.

Олон улсын коммунист хөдөлгөөний орчин үеийн асуудлуудаар БНХАУ-д нийтлэгдэж байгаа зохиол бүтээл, өгүүллийг авч үзвэл, Хятадын судлаачид ах дүү намын харилцааны зарчим, ХКН-аас коммунист, ажилчны намуудтай харилцаа тогтоохдоо голлон баримталж буй «бие даах» зарчмын талаар нэлээд сурталчилан бичиж байна.

Энэ асуудлаар БНХАУ-д гарсан нэлээд олон зохиол бүтээлд 1978 оны ХКН-ын Төв Хорооны III бүгд хурлаас тодорхойлсон чиг бодлого нь БНХАУ байгуулагдсанаас хойш ХКН-аас олон улсын коммунист хөдөлгөөнийг урагшлуулахад зохих хувь нэмэр оруулах сайхан боломжийг олгосон гэж дүгнэжээ.²⁷ Нам хоорондын харилцаан дахь бие даасан зарчим нь олон улсын коммунист хөдөлгөөний эв нэгдэл, хөгжилд хэрэгтэй юм гэж тэд үзэж байна.

Хятадын судлаачид 1960-аад оны дундуур «соёлын хувьсгалын» үед ХКН-д зүүний хэлбэрэл гарч, коммунист хөдөлгөөний зарим чухал асуудлаар «зүүний» үзэл баримталсан юм. Энэхүү «зүүний» үзэл бодлын үүднээс өөрийн намын байр сууриас өөр байр суурь баримталж буй бусад улс төрийн намын байр суурь болон зөвхөн өөрийн туршлага, практик дээр үндэслэн эдгээр намын бодлогыг үнэлж байв. Энэ нь зарим намын хувьд сөрөг нөлөө, хор уршигтай байсан юм. Хэт зүүний алдаатай үзэл бодлыг удирдлага болгосон учир олон улсын тавцан дээр ХКН-ын холбоотон улам улмаар цөөрч, олон улсын

коммунист хөдөлгөөний эв нэгдэлд хор хохирол учруулсан юм гэж судлаач эрдэмтэн Эр Лия* бичжээ.

Харин ХКН-ын Төв Хорооны бүгд хурлын үеэс ХКН тус намын гадаад бодлогод өөрчлөлт хийж эхлэв. Үүнтэй холбогдуулан Хятадын эрдэмтэд 1980 онд Дэн Сяопины дэвшүүлсэн нам хоорондын харилцааны зарчмыг голчлон иш татаж байна. Дэн Сяопин 1980 оны 5-р сарын 31-нд ХКН-ын Төв Хорооны хариуцлагатай ажилтан нартай ярилцах үеэр хэлэхдээ: «Улс орон бүрийн хэрэг явдал нь орон бүхний нам, ард түмэн хөгжлийн замаа өөрөө сонгон авах, шинжлэн судлах, асуудлыг бие дааж шийдвэрлэх явдлыг хүндэтгэхийг шаардаж байгаа бөгөөд үүнийг өөр нэг том намыг дагах шийдвэрлэж болохгүй. Энэ нь нэг чухал зарчим болох ёстой» гэж тэмдэглэжээ.

Эр Лия-гийн үзэж байгаагаар, нам хоорондын харилцаанд бие даасан, бүрэн эрх тэгш, харилцан хүндэтгэх, бие биеийн дотоод хэрэгт үл оролцох зарчим нь пролетарийн интернационализм, эх орон үзлийг нэгтгэн хослуулдагаараа коммунист хөдөлгөөний эв нэгдэлд ашигтай юм. «Орчин үеийн коммунист хөдөлгөн дотор оршиж байгаа хүний сэтгэл түгшүүлсэн эв нэгдэлгүй байгаа явдлын гол эх үүсвэр нь биеэ даасан зарчмыг хүндэтгээгүй байсанд оршино. Үүнтэй холбоотойгоор социалист орнуудын коммунист намууд бие даах зарчмаас татгалзаж, бусад орон, бусад намын дотоод хэрэгт оролцсон хэрэг гарсан юм. Манай нам бие даасан зарчмаас татгалзаж том намын байр сууринаас хагацах явдал, жанжлах үйл ажиллагааг шийдвэртэй эсэргүүцэж ирсэн нь зөв юм. Коммунист хөдөлгөөний эв нэгдэл нь бие даасан зарчмын үндсэн дээрх эв нэгдэл юм»²⁸ гэж тэрээр бичжээ.

Энэ асуудалтай холбогдуулан Хятадын эрдэмтэд социализмын нэг хэв загвар гэгчийг шүүмжилж, орон бүхний коммунист нам өврийн орны тодорхой нөхцөл байдалд үндэслэн социализм байгуулах замыг тодорхойлох ёстой гэж үзэж байна. «Энд социалист шинэчлэлтийн дүнд социализм байгуулах Зөвлөлтийн загварын хүлээснээс гарч, өөрийн орны бодит байдлыг иш үндэс болгон өөрийн замаар явж, Хятадын онцлогтой социализмыг байгуулах замыг эрэлхийлэх болов»²⁹ гэж Хятадын «Олон улсын коммунист хөдөлгөөн» хэмээх сэтгүүлд бичжээ.

Хятадын судлаачид орчин үеийн коммунист хөдөлгөөний нэг онцлог нь социализм олон төрөл янзтай болж байгаа явдал бөгөөд үүнтэй холбогдон ХКН-ын дэвшүүлсэн бие даах зарчим нь энэхүү олон янз хэлбэртэй болох үйл явцад түлхэц үзүүлэх ёстой юм гэж тэд үзэж байна. «Урьд бид манай орны хувьсгалын хэв загварыг бусад оронд тулган хүлээлгэхийг хүсэж байв. Одоо манай нам энэхүү алдаатай байр сууриа засаж, бусад хөгжиж байгаа орнууд Хятадын хэв загвараар хувьсгал хийх ёстой биш гэдгийг хүлээн зөвшөөрч байна... Жишээлбэл, манай нам Итали, Испани, Францын коммунист нам болон хөгжингүй капиталист орны коммунист намаас дэвшүүлсэн «еврокоммунизмын» талаархи үзэл онолд ямар нэгэн үнэлэлт дүгнэлт өгөөгүй юм, харин эдгээр намаас өөрийн орны тодорхой нөхцөлийг социализмын замыг эрэлхийлэх явдалтай холбох гэсэн явдлыг бүрэн хүндэтгэдэг юм. Бусад социалист орнууд, түүний дотор ЗХУ-ын со-

*Эр Лия-Хятадын ард түмний их сургуулийн улс төрийн факультетийн профессор эрдэмтэн юм.

циалист байгуулалтын тухайд, бид урт, богино гэж яриагүй бөгөөд харин өөрсдийн мэргэжилтэн нарыг эдгээр оронд явуулж тэдний туршлагыг судалж, суралцахыг эрмэлзэж байна»³⁰ гэж Эр Лия бичжээ.

Хятадын эрдэмтэд, орчин үед олон тооны коммунистууд биеэ дааж социалист хувьсгал, социализм байгуулах асуудлыг судалж эрэл хийж байна. Үүний зэрэгцээ тэд харилцан айлчлах, хоёр талын харилцан ярилцлагын хэлбэрийг ашиглан үзэл бодол, туршлагаа солилцож байгаа нь орон бүхний коммунистуудын эрэл хайгуулд тустай юм гэж үзээд, үүний үндсэн дээр, энэ нь коммунист хөдөлгөөнд гарч байгаа шинэ нэгдэл мөн» гэсэн дүгнэлтийг хийжээ. Гэхдээ тэд, энэхүү шинэ эв нэгдэл нь бие даасан, социализмын олон хэв загварын зарчимд үндэслэсэн юм гэж үзээд, пролетарийн интернационализм орчин үед илэрч байгаа шинэ илрэл гэж үзсэн байна.

Энэ бүхнээс үзэхэд, ХКН-аас олон улсын коммунист хөдөлгөөнтэй холбоо харилцаагаа өргөжүүлж байгаатай холбогдон Хятадад коммунист хөдөлгөөний асуудлаар судалгаа нэлээд өргөжиж Хятадын судлаачид зарим хуучин үзэл баримтлалаасаа татгалзаж, илүү бодитой үнэлэлт дүгнэлт хийх болсон нь харагдаж байна.

1. Хунци, 1982, No 18.
2. «Гуоцзи гунчаньчжун юньдун» «Олон улсын коммунист хөдөлгөөн» (хятад хэл дээр) 1987, № 4, 95 дахь тал.
3. «Гуоцзи гунчаньчжуи юньдун» (Олон улсын коммунист хөдөлгөөн) 1987, № 4, 95 96 дахь тал).
4. «Хуа дун шифань дасюэ сюэбао», 1986, № 3.
5. «Гуоцзи гунчаньчжуи юньдун», 1987, № 4,
6. Мөн тэнд.
7. «Шэхуй чжуи яньцзю». 1986. № 2.
8. «Шицзе лиши», 1986, № 11,
9. «Аньвай ши дасюэ». 1986, № 3.
10. «Бэйда сюэбао», 1986, № 5.
11. «Нанцзин шидасюэ бао», 1986, № 1.
12. «Сучжоу дасюэ сюэбао». 1986. № 2
13. «Бэйцзин дасюэ сюэбао». 1986, № 3
14. «Макэсы чжун Яньцзю», 1986, № 1
15. Синьян шифань дасюэ сюэбао», 1986, № 2
16. «Наньцзин шидасюэ бао», 1986, № 2
17. «Лилунь юэкань», 1986, № 2
18. «Гуоцзи гунюнь ши яньцзю», 1987, № 1, 4 дэх тал
19. «Макэсы Чжун яньцзю», 1986, № 1.
20. «Наньцзин ши дасюэ бао». 1986, № 2.
21. «Гуоцзи гунчаньчжуи юньдун», 1987, № 4, 16 дахь тал
22. «Сючан шичжуань сюэбао», 1986, № 2
23. «Гуоцзи гунюнь ши яньцзю», 1986. № 1
24. Мөн тэнд
25. «Гуоцзи гунюнь ши яньцзю». 1986. № 1
26. «Гуоцзи гунюнь ши яньцзю». 1987, № 1, 3 дахь тал
27. «Гуоцзи гунчаньчжуи юньдун», 1987. № 4, 125 дахь тал
28. Мөн тэнд
29. «Гуоцзи гунчаньчжуи юньдун», 1987. № 1
30. «Гуоцзи гунчаньчжуи юньдун», 1987, № 1, 12 дахь тал